



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/255

Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд тусгагдсан Булган сумын 11, 22 дугаар байрны орчин нөхцөл, өнгө үзэмжийг сайжруулах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 02 дугаартай зөвлөмжийн дагуу "Цонхот" ХХК-тай 58 845 507 /тавин найман сая найман зуун дөчин таван мянга таван зуун долоо/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т олгосугай

2. Гүйцэтгэгч "Цонхот" ХХК-тай холбогдох хууль, тогтоомжийн дагуу гэрээг байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Д.Буманбаяр/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Цонхот" ХХК /М.Цогт-Очир/-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ